



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/546

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Чандмань суманд “Бага оврын агаарын хөлгийн хөөрч, буух байгууламж” ажилд Ховд нисэх онгоцны буудал нь 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 202212006 дугаар гэрээний дагуу захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх зорилгоор 1,197,882 төгрөг (нэг сая нэг зуун ерэн долоон мянга найман зуун наян хоёр)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1,197,882 төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д даалгасугай.

4. Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар 22-ны өдрийн А/477 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Т.ДЭЛГЭРСАЙХАН

8400 01 2671  
Zan A/546 tum